



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр

Дугаар 375

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалт, Улсын дээд шүүхийн 2013 оны 465 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өр төлбөрийн хүрээнд бий болсон нийт 1,134,000,000.00 (нэг тэрбум нэг зуун гучин дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд хавсралтад заасны дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөрд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 09 дугаар сарын 05-ны өдрийн
3.7.5 дугаар тогтоолын хавсралт

"МИАТ" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/Д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	тоо ширхэг	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 хороо, 6 дугаар хороолол, 24 дүгээр байрны 1301 тоот 252 м2 талбайтай албан ажлын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	ш	1	1,134,000,000.00	1,134,000,000.00
	НИЙТ		1		1,134,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1 (нэг)		1,134,000,000.00 (нэг тэрбум нэг зуун гучин дөрвөн сая)